

Х-1, Д-1, ХН-326

**МОНГОЛ УЛСЫН АРВАН ДӨРӨВДҮГЭЭРИЙН ӨВӨЛ ЦАГ ЗАЛРУУЛАН ТОГТООСОН
ОЛОН ЯАМ БА АЛБАНЫ ГАЗРУУДЫН АЛБАН ХААГЧИД БА БАС БҮХ ҮЙЛДВЭРЧИН
АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН ХЭРЭГЛЭЛИЙН ДҮРЭМ**

Нэгдүгээр зэрэг гурван зуун төгрөг

Улсын их хурлын дарга

Хоёрдугаар зэрэг 260 төгрөг

Улсын бага хурлын дарга,

Улсын их хурлын дэд дарга

Гуравдугаар зэрэг 250 төгрөг

Засгийн газрын ерөнхий сайд

Дөрөвдүгээр зэрэг 180 төгрөг

Засгийн газрын жинхэнэ орлогч сайд

Олон яамны сайдууд

Эдийн засгийн зөвлөлийн тэргүүлэгч

Улсын их хурлын нарийн бичгийн дарга

Мөн улсын бага хурлын тэргүүлэгч гишүүд

Тавдугаар зэрэг 170 төгрөг

Засгийн газрын зөвлөх түшмэл

Зургадугаар зэрэг 160 төгрөг

Засгийн газрын нарийн бичгийн дарга

Мөн цааз хуулийг эмхлүүлэх хэлтсийн эрхэлсэн түшмэл

Хянан байцаах хэлтсийн дарга

Олон явдлын яамны эрхэлсэн, зөвлөх түшмэл

Судар бичгийн хүрээлэнгийн дарга

Дотоодыг хамгаалах газрын дарга

Долоодугаар зэргийн 150 төгрөг

Оюутны сургуулийн дарга, хавсарсан багш

Мөн эрдэмтэн багш

Наймдугаар зэрэг 140 төгрөг

Хотод сууж хэрэг шийтгэгч сайд

Тусгай газрын эрхэлсэн дарга

Есдүгээр зэрэг 130 төгрөг

Эдийн засгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга

Хянан байцаах хэлтсийн эрхэлсэн түмэл

Оюутны сургуулийн боловсон багш

Аймаг шавийн яамны дарга

Аравдугаар зэрэг 120 төгрөг

Улсын их хурал ба мөн бага хурлын гишүүд

Засгийн газрын хянан бртгэх түшмэл

Тэргүүн зэргийн орчуулагч, нягтлан бодогч түшмэл

Дунд сургуулийн захирал хавсарсан багш

Засгийн газрын олон яамны хэлтсийн эрхэлсэн түшмэл

Жин хэмжүүрийг эрхлэгч

Тусгай газрын туслах дарга

Оюутны сургуулийн багш

Хэвлэлийн хорооны дарга

Судар бичгийн хүрээлэнгийн түшмэл

Дээд зэргийн гаалийн хорооны эрхэлсэн түшмэл

Цахилгаан шуудангийн ерөнхий шийтгэх түшмэл

Сонин бичгийн эрхлэгч

Арван нэгдүгээр зэрэг 110 төгрөг

Хоёрдугаар зэргийн нягтлан бодос түшмэл

Дунд сургуулийн багш

Хэвлэлийн хорооны үсэг хянагч

Дотоодыг хамгаалах газрын тагнуулын мэдээ хураах дарга

Мөн газрын нарийн бичгийн дарга

Судар бичгийн хүрээлэнгийн номын сан хадгалагч, газар хэмжигч

Засгийн газрын төлөөний түшмэл

Арван хоёрдугаар зэрэг 100 төгрөг

Сангийн яам дотоодыг хамгаалах газар, хянан байцаах хэлтсийн байцаагч түшмэл

Дотоодыг хамгаалах газрын тагнуулын мэдээ хураах даргын туслах

Арван гуравдугаар зэрэг 90 төгрөг

Засгийн газар ба олон яамны хэлтсийн туслах түшмэл

Мөн хэлтсүүдийн салаа тасгийн эрхэлсэн түшмэл дарга

Сангийн яамны мөнгө барааны их нярав нар

Хотын сайдын яамны эрхэлсэн түшмэл

Хоёрдугаар зэргийн гаалийн хорооны эрхэлсэн түшмэл

Хоёрдугаар зэргийн орчуулагч

Засгийн газрын төлөөний түшмэлийн туслах

Аймаг шавийн яамны эрхэлсэн түшмэл

Гуравдугаар зэргийн нягтлан бодох түшмэл

Нийслэл хүрээний цахилгаан шуудангийн эрхлэгч

Телефон утасны боловсронгуй дарга

Тэргүүн зэрэг зурагч

Арван дөрөвдүгээр зэрэг 80 төгрөг

Нийслэлийн бага сургуулийн дарга хавсарсан багш

Аймаг шавийн яамны хэлтсийн эрхэлсэн түшмэл

Хотын сайдын яамны эрхэлсэн түшмэл

Гуравдугаар зэргийн гаалийн хорооны эрхэлсэн түшмэл

Цахилгаан шуудангийн салбар хорооны тшүмэл

Арван тавдугаар зэрэг 70 төгрөг

Салаа тасгийн туслах түшмэл

Аймаг шавийн яамны туслах түшмэл

Гуравдугаар зэргийн орчуулагч

Нийслэлийн бага сургуулийн багш

Нийслэлээс бусад газрын бага сургуулийн захирал хавсарсан багш

Дотоодыг хамгаалах газрын хязгаар орж гарагсдыг байцаагч

Тэргүүн зэргийн нягтлан бодох бичээч

Их гяндангийн эрхэлсэн түшмэл

Арван зургаадугаар зэрэг 65төгрөг

Засгийн газрын олон яамны хэлтсийн жинхэнэ бичээч нар

Машины бичээч

Хоёрдугаар зэргийн нягтлан бодох бичээч

Тэргүүн зэргийн хэлмэрч

Нийслэлээс бусад газрын бага сургуулийн багш

Сонин бичгийн сурвалжлагч

Хүн малын бага эмч

Арван долоодугаар зэрэг 55 төгрөг

Хотын сайдын яам ба аймаг шавийн яамны жинхэнэ бичээч нар

Нийслэлийн олон албан газрын туслах бичээч

Олон яам ба хотын сайдын яамны нярав нар

Дээд зэргийн гаалийн хорооны үзэгч

Арван наймдугаар зэрэг 50м төгрөг

Хотын сайдын яамны туслах бичээч

Нийслэлийн олон албаны газрын морьтой зарлага нар

Хоёрдугаар зэргийн хэлмэрч

Хөдөөгийн гаалийн хорооны үзэгч хавсарсан зарлага нар

Арван есдүгээр зэрэг 45 төгрөг

Хороо хэлтсийн газрын нярав нар

Хотын сайдын яам ба хөдөөний олон газруудын морьтой зарлага нар

Хорьдугаар зэрэг 40 төгрөг

Хотын сайдын яам ба аймаг шавийн яамны гяндангийн дарга нар

Хорин нэгдүгээр зэрэг 35 төгрөг

Нийслэл хорооны олон яам ба албаны газруудын галч, хөдөлмөрч, манаач, хуяг морьгүй зарлага нар

Хорин хоёрдугаар зэрэг 30 төгрөг

Хотын сайдын яам ба хөдөөгийн албан газруудын галч, хөдөлмөрч, манаач хуяг морь үгүй зарлага нар

Тайлбарлан тэмдэглэх нь:

Нэг. Энэхүү дүрмийн ёсоор албан хаагчдыг авч хэрэглэхүйд тухай бүр харьяат газрын сайд түшмэдээс чухам ямар зэрэг хэдий чинээ цалин хэрэглэл олгох явдлыг тогтоол, тусгай тогтоол үйлдэж, байцаах тэмдэг болгон дагаж явуулбаас зохимуй.

Хоёр. Хэрвээ энэхүү дүрмийн дотор эс дурдсан тушаалын орон гарваас чухам ямар үүрэгтэй болохыг илэрхийлэн тухайд засгийн газраа мэдүүлж аль зэрэг дугаараар явуулахыг тогтоол шийтгүүлбээс зохимуй.

Гурав. Нэгэн хүн хоёр жинхэнэ тушаалд ор хавсрах нь буй аваас дээдийн хэрэглэлийг олгож нөгөө тушаалын цалингийн зуун хувийн гучин хувийг олговоос зохимуй. Үүнд ямар нэгэн тушаалын оронд бусад тушаалын нэр үүргийг хавсаргахаар засгийн газраас тогтоосон нь болбоос нь давхар хэрэглэл олгохыг хэрэгсэхгүй жич аливаа нааш тушаалын хүн дээд буюу доорд зэргийн албаныг түр орловоос уг тушаалын хүний цалинг авч бүхий цагт орлосон хүнд цалин нэмэхгүй зөвхөн жинхэнэ тушаалын цалинг олгомуй.

Дөрөв. Аливаа албаны газар сургагч нарыг авч хэрэглэх нь болбоос түүний цалинг харьяат газрын эрхлэх түшмэл даргын зэргийн хүний цалингаас хэтрүүлэхгүйгээр олгомуй.

Тав. Ямар нэгэн газарт өгч боловсронгуй эрдэмтэн хүний авч авч хэрэглэхүйд тогтоосон цалин хэрэглэл үнэхээрийн хомстох аваас зохих газраас олгох зохих цалин хэрэглэлийг төсөвлөн засгийн газраа мэдүүлж, батлан тогтоолговоос зохимуй.

Зургаа. Аливаа албан хаагчид тус улсын харьяат газраа албан хэргээр явахад уг цалингийн дээр замын зарлага хэмээн нэмж олгохгүй гагцхүү гадаад улсад явах нь буй аваас нэгдүгээрээс тавдугаар хүртэлх зэргийн албан хаагчдад уг цалингийн дээр нэгэн адил хувь нэммүй. Бусад зэргийн албан хаагчдад өдөр тутам нэгэн төгрөг тавин мөнгөөс хэтрүүлэлгүй нэмэн олгох цаг, гадна суух орон байшин замын хөлс зэргийг сангаас олгомуй.

Долоо. Аливаа албаны газраас сар бүрийн цалингийн хэрэглэлийн мөнгийг хүлээн авахүйд харьяат албан хаагчдын нэр тоо, олговоос зохих мөнгийг тусгай хүснэгт жагсаан бичиж, эрхлэх сайд түшмэд, дарга нарын үсэг зуруулан ... хэмээх хуудас дагалдуулан сангийн яамнаа явуулж гүйцэтгүүлбээс зохимуй.

Монгол улсын арван тавдугаарын билиг, аргын улирлын есөн сарын арван гурваны өдрөө хуралдсан засгийн газрын гучин долоодугаар хурлын тавдугаар зүйлд баталсан нь мөн оны илүү арван сарын зургаан бөгөөд аргын арван хоёр сарын арван хоёрын өдрөө засгийн газрын дөчин дөрөвдүгээр хурлын арван дөрөвдүгээр зүйлд бага сага залруулан засаж баталжээ.